

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/174/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН МӨНГӨНМОРЬТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2021
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч: Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК

Утас: 99884842 Цахим хаяг: gereltekhburtgelaudit02@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Төлбөрийн акт.....	17
4.3 Албан шаардлага	17
4.4 Зөвлөмж	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/155
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН МӨНГӨНМОРЬТ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Б.БАТЧИМЭГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2021 19030/89
Ор АЛБАН БИЧИГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>43,096,407.31</u>	<u>160,172,825.89</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	999,799.90
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	999,799.90
3121	Төгрөг	-	999,799.90
31211	Төрийн сангийн харилцах	-	737,541.20
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	262,258.70
33	АВЛАГА	-	62,288,295.31
335	Бусад авлага	-	62,288,295.31
3351	Байгууллагаас авах авлага		62,288,295.31
35	БАРАА МАТЕРИАЛ	43,096,407.31	96,884,730.68
351	Түүхий эд материал	20,670,210.01	70,647,889.52
35130	Эм боох материал	20,670,210.01	70,647,889.52
354	Хангамжийн материал	22,426,197.30	26,236,841.16
35410	Бичиг хэргийн материал	2,030,696.00	2,307,696.00
35420	Аж ахуйн материал	15,585,338.00	18,120,562.00
35440	Түлш, шатах тослох материал	2,038,795.30	4,957,373.16
35460	Хүнсний материал	2,771,368.00	171,210.00
35470	Бусад хангамжийн материал		680,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>512,560,638.06</u>	<u>587,005,072.89</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	512,560,638.06	587,005,072.89
392	Биет хөрөнгө	504,146,638.06	578,591,072.89
39201	Барилга, байгууламж, орон сууц	478,921,795.00	478,921,795.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(19,919,579.52)	(32,909,876.16)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	50,046,434.00	127,046,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(32,379,347.68)	(37,656,253.26)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	80,237,593.49	106,833,551.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	(59,902,694.75)	(69,626,573.11)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,152,795.84	19,152,795.84
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,936,646.30)	(14,266,046.46)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,370,700.00	1,710,995.45
39302	Хуримтлагдсан элэгдэл	(444,412.02)	(615,749.46)
393	Биет бус хөрөнгө	8,414,000.00	8,414,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,414,000.00	8,414,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>555,657,045.37</u>	<u>747,177,898.78</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>9,816,988.50</u>
412	Богино хугацаат зээлийн өглөг	-	9,816,988.50
413	Өглөг	-	9,816,988.50
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,302,199.10
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	8,458,686.80
4136	Бусад өглөг	-	56,102.60
41361	Байгууллагад төлөх өглөг	-	56,102.60
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>555,657,045.37</u>	<u>737,360,910.28</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	555,657,045.37	737,360,910.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	312,003,456.19	312,003,456.19
51101	Өмч: - төрийн	312,003,456.19	312,003,456.19
512	Хуримтлагдсан үр дүн	243,653,589.18	338,490,712.21

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51210	Өмнөх үеийн үр дүн	156,786,847.30	156,786,847.30
51220	Тайлант үеийн үр дүн		181,703,864.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	86,866,741.88	86,866,741.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>555,657,045.37</u>	<u>747,177,898.78</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	179,834,916.85	900,172,828.84
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,208,636.85	352,952,723.84
120	Нийтлэг татварын бус орлого	8,208,636.85	352,952,723.84
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,208,636.85	352,952,723.84
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,208,636.85	352,952,723.84
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	31,059,480.00	220,378,705.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	140,566,800.00	326,841,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	900,000.00	173,676,755.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	900,000.00	173,676,755.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	19,672,500.00	37,179,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	19,672,500.00	37,179,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	10,486,980.00	9,522,950.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	10,486,980.00	9,522,950.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	178,267,374.95	718,176,663.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	178,267,374.95	718,176,663.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	178,267,374.95	711,501,213.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	111,782,063.31	254,985,471.54
210101	Үндсэн цалин	76,119,600.00	195,402,864.54
210102	Нэмэгдэл	26,985,599.41	49,185,471.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		2,280,000.00
210104	Урамшуулал	8,676,863.90	8,117,136.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,946,834.65	33,063,897.46
210201	Тэтгэврийн даатгал	9,904,749.95	23,409,735.34
210202	Тэтгэмжийн даатгал	1,075,663.99	2,610,361.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	860,533.19	2,031,170.27
210204	Ажилгүйдлийн даатгал	190,117.85	455,694.11
210205	Эрүүл мэндийн даатгал	1,915,769.67	4,556,936.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,626,598.13	30,318,849.19
210301	Гэрэл, цахилгаан	1,985,098.13	3,081,849.19
210302	Түлш, халаалт	15,641,500.00	26,937,000.00
210303	Цэвэр, бохир ус		300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,008,691.00	19,786,574.97
210401	Бичиг хэрэг	1,297,040.00	2,207,100.00
210402	Тээвэр, шатахуун	5,096,141.00	15,716,454.97
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	486,810.00	1,122,920.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	128,700.00	740,100.00

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2105	Нормативт зардал	13,885,263.48	304,059,932.19
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,976,801.93	289,990,868.29
210502	Хоол, хүнс	2,908,461.55	12,441,777.90
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,627,286.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	4,856,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		1,906,200.00
210604	Урсгал засвар		2,950,700.00
2107	Томилолт, зочны зардал	330,000.00	1,432,100.00
210702	Дотоод албан томилолт	330,000.00	1,432,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	30,957,856.99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		30,957,856.99
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,687,924.38	32,039,630.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,277,042.00	2,547,812.60
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,410,882.38	29,491,818.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	6,675,450.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,008,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,008,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		5,667,450.81
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		5,667,450.81
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,567,541.90</u>	<u>181,996,164.91</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	730,001.08	292,300.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	730,001.08	
145003	Үнэ төлбөргүй гарсан зардал		292,300.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	(730,001.08)	(292,300.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>837,540.82</u>	<u>181,703,864.91</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	312,003,456.19	87,296,162.28	(69,782,353.43)	329,517,265.04
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			429,420.40	429,420.40
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	312,003,456.19	87,296,162.28	(69,352,933.03)	329,946,685.44
C07	Тайлант үеийн үр дүн	-		837,540.82	837,540.82
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	312,003,456.19	86,866,741.88	156,786,847.30	555,657,045.37
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	312,003,456.19	86,866,741.88	156,786,847.30	555,657,045.37
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	312,003,456.19	86,866,741.88	156,786,847.30	555,657,045.37
D08	Тайлант үеийн үр дүн	-		181,703,864.91	181,703,864.91
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	312,003,456.19	86,866,741.88	338,490,712.21	737,360,910.28

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>171,626,280.00</u>	<u>487,953,705.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	171,626,280.00	487,953,705.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	19,672,500.00	37,179,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	19,672,500.00	37,179,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	140,566,800.00	326,841,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	900,000.00	114,410,355.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	900,000.00	114,410,355.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	10,486,980.00	9,522,950.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	10,486,980.00	9,522,950.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>157,869,550.13</u>	<u>484,903,905.10</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	157,869,550.13	484,903,905.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	157,869,550.13	478,228,454.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	110,517,821.41	253,581,748.90
210101	Үндсэн цалин	76,119,600.00	157,632,896.90
210102	Нэмэгдэл	26,985,599.41	65,283,332.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		3,901,120.00
210104	Урамшуулал	7,412,622.00	26,764,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,946,629.54	33,091,072.00
210201	Тэтгэврийн даатгал	10,308,578.08	23,598,680.15
210202	Тэтгэмжийн даатгал	1,079,762.02	2,630,381.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	713,889.20	2,057,245.00
210204	Ажилгүйдлийн даатгал	159,157.85	468,443.65
210205	Эрүүл мэндийн даатгал	1,685,242.39	4,336,321.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,136,598.13	30,318,849.19
210301	Гэрэл, цахилгаан	1,985,098.13	3,081,849.19
210302	Түлш, халаалт	15,151,500.00	26,937,000.00
210303	Цэвэр, бохир ус		300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,966,850.00	21,939,320.00
210401	Бичиг хэрэг	421,700.00	1,326,900.00
210402	Тээвэр, шатахуун	5,500,000.00	18,325,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	602,150.00	1,199,920.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	443,000.00	1,086,900.00
2105	Нормативт зардал	6,438,609.05	93,693,912.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,048,000.00	89,644,087.80
210502	Хоол, хүнс	3,390,609.05	4,049,825.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	820,600.00	7,392,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	468,000.00	1,600,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	352,600.00	3,099,600.00
210604	Урсгал засвар		2,692,700.00
2107	Томилолт, зочны зардал	198,000.00	1,432,100.00

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	198,000.00	1,432,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	31,055,541.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		31,055,541.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,844,442.00	5,723,610.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,844,442.00	5,723,610.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	6,675,450.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,008,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,008,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	5,667,450.81
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		5,667,450.81
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>13,756,729.87</u>	<u>3,049,799.90</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	13,756,729.87	999,799.90
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,756,729.87	999,799.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	499,203,355.00	486,953,905.10	12,249,449.90	97.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	499,203,355.00	486,953,905.10	12,249,449.90	97.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	498,195,355.00	480,278,454.29	17,916,900.71	96.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	258,661,300.00	253,581,748.90	5,079,551.10	98.04
210101	Үндсэн цалин	178,429,100.00	157,632,896.90	20,796,203.10	88.34
210102	Нэмэгдэл	48,175,800.00	65,283,332.00	(17,107,532.00)	135.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,292,000.00	3,901,120.00	1,390,880.00	73.72
210104	Урамшуулал	26,764,400.00	26,764,400.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,919,200.00	33,091,072.00	1,828,128.00	94.76
210201	Тэтгэврийн даатгал	24,572,800.00	23,598,680.15	974,119.85	96.04
210202	Тэтгэмжийн даатгал	2,586,600.00	2,630,381.33	(43,781.33)	101.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,069,300.00	2,057,245.00	12,055.00	99.42
210204	Ажилгүйдлийн даатгал	517,300.00	468,443.65	48,856.35	90.56
210205	Эрүүл мэндийн даатгал	5,173,200.00	4,336,321.87	836,878.13	83.82

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,979,000.00	30,318,849.19	5,660,150.81	84.27
210301	Гэрэл, цахилгаан	8,742,300.00	3,081,849.19	5,660,450.81	35.25
210302	Түлш, халаалт	26,936,700.00	26,937,000.00	(300.00)	100.00
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	300,000.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,220,000.00	21,939,320.00	1,280,680.00	94.48
210401	Бичиг хэрэг	1,500,000.00	1,326,900.00	173,100.00	88.46
210402	Тээвэр, шатахуун	18,420,000.00	18,325,600.00	94,400.00	99.49
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,199,920.00	300,080.00	79.99
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,800,000.00	1,086,900.00	713,100.00	60.38
2105	Нормативт зардал	97,644,100.00	93,693,912.90	3,950,187.10	95.95
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	89,644,100.00	89,644,087.80	12.20	100.00
210502	Хоол, хүнс	8,000,000.00	4,049,825.10	3,950,174.90	50.62
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,900,000.00	8,892,300.00	7,700.00	99.91
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,600,000.00	1,600,000.00	-	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,100,000.00	3,099,600.00	400.00	99.99
210604	Урсгал засвар	4,200,000.00	4,192,700.00	7,300.00	99.83
2107	Томилолт, зочны зардал	1,538,100.00	1,432,100.00	106,000.00	93.11
210702	Дотоод албан томилолт	1,538,100.00	1,432,100.00	106,000.00	93.11
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,060,000.00	31,055,541.30	4,458.70	99.99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,060,000.00	31,055,541.30	4,458.70	99.99
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,273,655.00	6,273,610.00	45.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,273,655.00	6,273,610.00	45.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,008,000.00	6,675,450.81	(5,667,450.81)	662.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,008,000.00	1,008,000.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,008,000.00	1,008,000.00	-	100.00
	Олгосон санхүүжилт шилжүүлэг		5,667,450.81	(5,667,450.81)	
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		5,667,450.81	(5,667,450.81)	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	499,179,055.00	487,953,705.00	11,225,350.00	97.75
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	326,841,400.00	326,841,400.00	-	100.00

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	326,841,400.00	326,841,400.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	37,179,000.00	37,179,000.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	37,179,000.00	37,179,000.00	-	100.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	20,848,300.00	9,522,950.00	11,325,350.00	45.68
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	20,848,300.00	9,522,950.00	11,325,350.00	45.68
	Нэмэлт санхүүжилтийн орлого	114,310,355.00	114,410,355.00	(100,000.00)	
	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	114,310,355.00	114,410,355.00	(100,000.00)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	999,799.00	(999,799.00)	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны
		Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	114,148,096.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	114,148,096.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	113,140,096.30
2104	Хангамж, бараа материалын зардал	500,000.00
210401	Бичиг хэрэг	500,000.00
2105	Нормативт зардал	78,072,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	77,754,900.00
210502	Хоол, хүнс	317,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	38,100.00
210702	Дотоод албан томилолт	38,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,055,541.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,055,541.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	473,655.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	473,655.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,008,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,008,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,008,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	114,410,355.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	114,410,355.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	114,410,355.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	262,258.70

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн ашиглалт, цалингийн тооцоолол, татварын хуулийн хэрэгжилт, шилэн дансны хэрэгжилтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторын туслах Э.Алтангэрэл, аудиторын туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Мөнгөн морьт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 7,439.8 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,579.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	999.8	999.8
Авлага	-	62,288.3	62,288.3
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	43,096.4	96,884.7	53,788.3
Үндсэн хөрөнгө	512,560.6	587,005.1	74,444.5
Нийт хөрөнгө	555,657.1	747,177.8	191,520.7
Өр төлбөр	-	9,816.9	9,816.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	555,657.1	737,360.9	181,703.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	555,657.1	747,177.8	191,520.7

Авлага дансны үлдэгдэл 62,288.3 мянган төгрөг болж нэмэгдсэн нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас санхүүжүүлэх Ковид 19-тэй холбоотой эмчилгээ үйлчилгээний 62,288.3 мянган төгрөгийг авлагад тусгаснаас шалтгаалжээ. Авлагын дансны үлдэгдэлд тусгагдсан Эрүүл мэндийн даатгалаас авах 62,288.3 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 96,884.7 мянган төгрөг болж, 53,788.3 мянган төгрөгөөр өссөн нь Ковид 19 цар тахалтай холбоотой хандиваар ирсэн хөрөнгүүд нэмэгдсэнээс шалтгаалсан байна. Үүнд:

Эрүүл мэндийн газраас 198,881.3 мянган төгрөгийн вакцин, саагийн вакцин, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, хамгаалах хувцас хэрэгсэл, эм бэлдмэл, Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газраас 50,005.4 мянган төгрөгийн тусгаарлах байрны хоол хүнсний материал, аж ахуйн материал, эм бэлдмэл, хамгаалах хэрэгсэл, Иргэнээс

хамгаалах хэрэгслийн 360.0 мянган төгрөгөөр, нийт 249,246.7 мянган төгрөгийн хөрөнгө хандивласан байна.

Бараа материалын данс акталж устгасан аж ахуйн материал, эм боох материалын 2,893.6 мянган төгрөгөөр хасагджээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 587,005.1 мянган төгрөг болж, 74,444.5 мянган төгрөгөөр өссөн. Үндсэн хөрөнгийн данс Ковид 19 цар тахалтай холбоотой хандиваар ирсэн хөрөнгүүдээр нэмэгдсэн байна. Үүнд:

Эрүүл мэндийн газраас 11,386.2 мянган төгрөгийн вакцин зөөврийн сав, мөсөн ханатай хөргөгч, компьютер суурин, хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппарат, Онцгой байдлын газраас 43,000.0 мянган төгрөгийн Фургон автомашин, Мөнгөн морьт сумын Засаг даргын Тамгын газраас 34,000.0 мянган төгрөгийн Starex маркийн автомашин, 11,500.0 мянган төгрөгийн биохимийн анализатор, хүчилтөрөгчийн аппарат, 1 иргэнээс 2,000.0 мянган төгрөгийн хүчилтөрөгчийн аппарат, принтер, 1 иргэнээс 2,000.0 мянган төгрөгийн, нийт 101,886.2 мянган төгрөгийн хөрөнгө хандивласан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд ХХОАТ-т өгөх 1,302.2 мянган төгрөгийн, 2 байгууллагад өгөх 8,514.8 мянган төгрөгийн хоол хүнс, эмний тооцоотой холбоотой өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Өр төлбөрийн дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 89,662.1 мянган төгрөгөөр өссөн. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна. Энэ нь үндсэн хөрөнгө бараа материалын дансанд хандиваар ирсэн 352,952.7 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны зардал өмнөх оноос 539,909.3 мянган төгрөгөөр өссөн. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан эмийн зардал байна. Энэ нь Ковид 19-тэй холбоотой эмийн зарцуулалт нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа үйлчилгээний бусад зардал өссөн нь Ковид-19-тэй холбоотой үйлчилгээ эмчилгээ нэмэгдсэнээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 438,957.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 438,957.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 54,089.0 мянган төгрөгөөр бууруулж, 384,868.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрийн 35 арга хэмжээг санхүүжүүлэхээр 384,868.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 326,841.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 37,179.0 мянган төгрөгийг орон нутгийн сангаас, 20,848.3 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 326,841.4 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 37,179.0 мянган төгрөгийн, эрүүл мэндийн сангаас 20,848.3 мянган төгрөгийн, нийт 373,543.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, бараа, үйлчилгээний зардалд 367,113.6

мянган төгрөгийг зарцуулж, 5,667.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газраас Ковид-19 өөр хэвтэн эмчлүүлсэн, гэрийн тусгаарлалтад хамрагдсан, дархлаажуулалтад хамрагдсан өвчтөнүүдийн эмчилгээ үйлчилгээний төлбөрийн 114,410.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 114,410.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 114,148.1 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 262.5 мянган төгрөгийн төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 89,662.1 мянган төгрөгөөр өссөн. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна. Энэ нь үндсэн хөрөнгө бараа материалын дансанд хандиваар ирсэн 352,952.7 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны зардал өмнөх оноос 539,909.3 мянган төгрөгөөр өссөн. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан эмийн зардал, бараа ажил үйлчилгээний бусад зардал байна. Энэ нь Ковид 19-тэй холбоотой эм, нэг хэрэглэдэг хувцас хэрэглэлийн зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 475,385.5 мянган төгрөгийн 39 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 262,650.7 мянган төгрөгийн 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн авлагатай холбоотой 1 акт, И баримттай холбоотой 1 зөвлөмж, шилэн данстай холбоотой 1 зөвлөмж, нийт 3 алдаа зөрчлийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	167.3	1	167.3	-	-	-
Зөвлөмж	2	14,279.7	2	14,279.7	-	-	-
Нийт дүн	3	14,447.0	3	14,447.0	-	-	-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 268,311.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2,050.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 34.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3,575.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 262,650.7 мянган төгрөгийн шилэн данстай холбоотой зөвлөмж болон үндсэн хөрөнгийн данстай холбоотой зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын зардлын дүнд худалдан авсан 2,050.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тайлагнаагүй, үндсэн үйл ажиллагааны зардалд тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 6.9-д “Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны зарлага хэсэгт ,, үндсэн хөрөнгө худалдан авах, олж бэлтгэхэд болон капиталжих их засварт зарцуулсан мөнгөн зардлыг харуулна”, санхүүгийн тайлангийн аудитын “тодруулга ба толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Нэг ажилтны цалингаас ХХОАТ-ыг огт тооцоогүйгээс ХХОАТ-ын 34.7 мянган төгрөгийг цалингаас дутуу суутгасан;

Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна”, 23 дугаар зүйлийн 23.1-д “Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ”, 7.1.6-д “Үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого”, санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” заалтыг үндэслэн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Байгууллага нь нийт 7 аж ахуй нэгж байгууллагатай холбоотой 3,575.7 мянган төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгээгүй, и-баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй”, санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.8-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй 126 ширхэг 101,994.6 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна", 6.2.1-д "Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон", санхүүгийн тайлангийн аудитын "үнэлгээ ба хуваарилалт", "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

2. Шилэн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 475,385.5 мянган төгрөгийн 39 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 262,650.7 мянган төгрөгийн 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам", санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт болон Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:											
1	Хандиваар ирсэн хөрөнгийг худалдан авсан хөрөнгөөр бүртгэсэн	1	2,050.0	1	2,050.0						
3	Цалинг буруу тооцоолж олгосон	1	34.7			1	34.7				
5	Худалдан авалтыг И баримтаар баталгаажуулаагүй	1	3,575.7					1	3,575.7		
6	Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байна	1	-							1	-
Дүн		4	5,660.4	1	2,050.0	1	34.7	1	3,575.7	1	-
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:											
1	Шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй	1	262,650.7							1	262,650.7
Дүн		1	262,650.7	-	-	-	-	-	-	1	262,650.7
Нийт дүн		5	268,311.1	1	2,050.0	1	34.7	1	3,575.7	2	262,650.7